



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

**Аудитын код:** ТӨА-2025/106/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Туунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.08.25 № 01/86  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
С.БУЛГАНЧИМЭГ ТАНАА

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт 21,413.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ урсгал засварын зардлаас 2,749.2 мянган төгрөг, 185.0 мянган төгрөгийн зардлыг шуудан холбооны, багаж хэрэгслийн зардлаас 17,090.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 1,389.0 мянган төгрөгийг зориулалт бусаар олгосон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу

412506474

олгогдож буй нэг иргэнд ногдох норматив санхүүжилт, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний 2024 оны 7-12 дугаар сарын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын

ерөнхий газраас олгоогүйн улмаас 96,947.3 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд гүйцэтгэсэн үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний 241,158.3 мянган төгрөгийн орлогыг Эрүүл мэнд даатгалын ерөнхий газраас нэхэмжилсэн ба тус газрын хяналт баталгаажуулалтаар нэхэмжлэхийн дүнгээс хасагдсан 22,328.9 мянган төгрөгийн зөрчилтэй гүйлгээний дүнгээр тайлант оны орлогыг бууруулж тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95,9 %-ийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>180,873,482.78</b>	<b>204,778,587.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>66,842,166.82</b>	<b>3,967,975.87</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	66,842,166.82	3,967,975.87
3121	Төгрөг	66,842,166.82	3,967,975.87
31211	Төрийн сангийн харилцах	66,842,166.82	3,967,975.87
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>21,598,897.92</b>	<b>127,224,740.67</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	18,772,420.00	127,224,740.67
335	Бусад авлага	2,826,477.92	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,826,477.92	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>92,432,418.04</b>	<b>73,585,870.58</b>
351	Түүхий эд материал	71,195,513.04	50,832,425.08
35110	Тусгай зориулалттай материал	39,326,593.27	25,184,439.68
35130	Эм боох материал	31,868,919.77	25,647,985.40
354	Хангамжийн материал	21,236,905.00	22,753,445.50
35410	Бичиг хэргийн материал	83,000.00	99,500.00
35420	Аж ахуйн материал	19,268,050.00	15,706,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	110,000.00	1,800,000.00
35460	Хүнсний материал	274,355.00	355,595.50
35470	Бусад хангамжийн материал	1,501,500.00	4,792,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>964,276,294.24</b>	<b>1,279,317,588.19</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>964,276,294.24</b>	<b>1,279,317,588.19</b>
392	Биет хөрөнгө	962,485,183.12	1,241,816,477.05
39201	Барилга, байгууламж	775,420,497.30	775,420,497.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,689,137.30	-58,050,866.55
39203	Авто тээврийн хэрэгсэл	65,600,000.00	245,499,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,144,333.19	-41,916,333.13
39205	Машин, тоног төхөөрөмж	259,961,343.06	417,429,264.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,123,042.84	-152,268,753.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,974,476.98	90,429,362.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,506,176.89	-35,717,615.83
39217	Номын фонд	991,556.00	991,556.00
393	Биет бус хөрөнгө	1,791,111.12	37,501,111.14
39301	Программ хангамж	825,000.00	26,055,000.00
39302	Хасагдуулаг	-433,888.88	-543,888.86
39303	Бусад биет бус хөрөнгө	1,400,000.00	11,990,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,145,149,777.02</b>	<b>1,484,096,175.31</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>251.00</b>	<b>261.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>251.00</b>	<b>261.00</b>
413	Өглөг	251.00	261.00
4136	Бусад өглөг	251.00	261.00
*	Эмийн өглөг	251.00	261.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,145,149,526.02</b>	<b>1,484,095,914.31</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,145,149,526.02	1,484,095,914.31
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	606,283,482.44	606,283,482.44
51101	Өмч: -Төрийн өмч	606,283,482.44	606,283,482.44
512	Хуримтлагдсан үр дүн	410,180,902.34	749,127,290.63
51210	Өмнөх үеийн үр дүн	410,180,902.34	410,180,902.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	338,946,388.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,685,141.24	128,685,141.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,145,149,777.02</b>	<b>1,484,096,175.31</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>968,610,342.03</b>	<b>1,511,353,089.75</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>158,503,904.24</b>	<b>397,810,374.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>158,503,904.24</b>	<b>397,810,374.55</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,295,910.00	2,500,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,295,910.00	2,500,000.00
120009	Бусад орлого	-	956,302.62
120017	Үнэгүй авсан - Үндсэн хөрөнгө	121,270,279.00	362,629,012.87
120018	Үнэгүй авсан - Бараа материал	35,937,715.24	31,725,059.06
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>810,106,437.79</b>	<b>1,113,542,715.20</b>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,488,900.00	113,130,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,488,900.00	113,130,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	746,617,537.79	1,000,412,715.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	746,617,537.79	1,000,412,715.20
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>942,116,470.71</b>	<b>1,141,721,619.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>942,116,470.71</b>	<b>1,141,721,619.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>919,930,492.63</b>	<b>1,080,346,719.27</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	506,996,873.76	678,134,929.11
210101	Цалин	307,185,083.63	312,655,875.90
210102	Нэмэгдэл цалин	164,725,626.11	363,148,053.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,795,000.00	2,331,000.00
210104	Урамшуулал	30,291,164.02	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,907,999.48	87,240,673.31
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	41,401,592.44	60,577,653.07
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,833,624.82	6,336,547.96
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,119,924.39	4,303,904.33
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	892,450.83	3,026,513.10
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,660,407.00	12,996,054.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,102,921.92	49,555,099.61
210301	Гэрэл цахилгааны зардал	4,010,690.92	4,254,899.61
210302	Түлш, халаалтын зардал	34,792,231.00	44,893,200.00
210303	Цэвэр, бохир усны зардал	300,000.00	407,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,246,900.00	72,362,138.53
210401	Бичиг хэргийн материал	5,757,000.00	5,169,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	41,801,400.00	34,326,480.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,080,500.00	2,176,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,317,000.00	6,086,500.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	3,590,000.00	24,604,158.53
210408	Бараа материал актасны зардал	24,701,000.00	-
2105	Нормативт зардал	126,975,865.65	105,088,209.79
210501	Эм	107,977,741.65	89,477,510.29
210502	Хоол	18,998,124.00	15,610,699.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,255,000.00	12,063,500.00
210601	Багаж хэрэгсэл	-	80,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,322,500.00	-
210604	Урсгал засвар	19,932,500.00	11,983,500.00
2107	Томиллот, зочны зардал	2,214,000.00	1,780,000.00
210702	Дотоод томиллотын зардал	2,214,000.00	1,780,000.00

**Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,814,163.00	1,508,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,209,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	381,675.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,144.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	40,344.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,416,768.82	72,614,168.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,382,589.08	5,013,290.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,034,179.74	67,600,878.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,185,978.08	61,374,900.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,185,978.08	61,374,900.39
213403	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	22,185,978.08	61,374,900.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>26,493,871.32</b>	<b>369,631,470.09</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	30,685,081.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	30,685,081.80
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	-	<b>(30,685,081.80)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>26,493,871.32</b>	<b>338,946,388.29</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>779,714,499.78</b>	<b>1,010,719,272.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,502,682.00</b>	<b>5,628,877.92</b>
120	Нийтлэг татварын бус орлого	7,502,682.00	5,628,877.92
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,502,682.00	2,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,502,682.00	2,500,000.00
120009	Бусад орлого	-	3,128,877.92
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>772,211,817.78</b>	<b>1,005,090,394.53</b>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,488,900.00	113,130,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,488,900.00	113,130,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	708,722,917.78	891,960,394.53
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	708,722,917.78	891,960,394.53
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>832,860,539.24</b>	<b>1,073,593,463.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>832,860,539.24</b>	<b>1,073,593,463.40</b>
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,674,561.16	1,012,218,563.01
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	506,996,873.76	682,284,037.62
210101	Үндсэн цалин	307,185,083.63	406,820,392.54
210102	Нэмэгдэл	164,725,626.11	249,658,995.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,795,000.00	2,331,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал	30,291,164.02	23,473,650.00
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,186,816.48	82,437,662.18
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	41,103,538.74	56,785,514.66
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,336,905.61	6,457,793.52
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,119,924.39	4,061,788.62
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	966,040.74	3,026,513.10
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,660,407.00	12,106,052.28
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	39,102,921.92	49,555,099.61
210301	Гэрэл цахилгааны зардал	4,010,690.92	4,254,899.61
210302	Түлш, халаалтын зардал	34,792,231.00	44,893,200.00
210303	Цэвэр, бохир усны зардал	300,000.00	407,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,496,200.00	53,892,980.00
210401	Бичиг хэрэг	5,757,000.00	5,185,500.00
210402	Тээвэр, шатахуун	41,591,400.00	34,326,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,080,500.00	2,361,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,317,000.00	5,580,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,300.00	6,440,000.00
2105	Нормативт зардал	109,686,186.00	96,486,533.60
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,286,636.00	79,369,593.60
210502	Хоол, хүнс	17,399,550.00	15,691,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,425,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,646,200.00	35,047,660.00
210601	Багаж техник хэрэгсэл	1,100,000.00	18,693,500.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	2,237,200.00	1,558,000.00
210604	Урсгал засвар	11,309,000.00	14,796,160.00
2107	Томиллолт, зочны зардал	2,214,000.00	1,780,000.00
210702	Дотоод албан томиллолт	2,214,000.00	1,780,000.00

**Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,814,163.00	1,508,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	779,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	381,675.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,144.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	40,344.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,531,200.00	9,226,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,531,200.00	9,226,590.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,185,978.08	61,374,900.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,185,978.08	61,374,900.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,185,978.08	61,374,900.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-53,146,039.46	-62,874,190.95
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,787,300.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,787,300.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	47,787,300.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,787,300.00	-
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(47,787,300.00)</b>	-
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(100,933,339.46)</b>	<b>(62,874,190.95)</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>167,775,506.28</b>	<b>66,842,166.82</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>66,842,166.82</b>	<b>3,967,975.87</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>606,283,482.44</b>	-	<b>183,121,559.88</b>	<b>789,405,042.32</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	606,283,482.44	-	183,121,559.88	789,405,042.32
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	123,570,396.27	123,570,396.27
<b>C08</b>	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>606,283,482.44</b>	-	<b>410,180,902.34</b>	<b>1,016,464,384.78</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	606,283,482.44	-	410,180,902.34	1,016,464,384.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	338,946,388.29	338,946,388.29
<b>D09</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>606,283,482.44</b>	-	<b>749,127,290.63</b>	<b>1,355,410,773.07</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,103,324,700.00	1,012,218,573.01	(91,106,126.99)	91.7
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,103,324,700.00	1,012,218,573.01	(91,106,126.99)	91.7
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,103,324,700.00	1,012,218,573.01	(91,106,126.99)	91.7
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	769,511,000.00	684,639,037.62	(84,871,962.38)	89.0
Үндсэн цалин	443,007,900.00	409,175,392.54	(33,832,507.46)	92.4
Нэмэгдэл	284,216,600.00	249,658,995.08	(34,557,604.92)	87.8
Унаа хоолны хөнгөлөлт	10,220,000.00	2,331,000.00	(7,889,000.00)	22.8
Урамшуулал	32,066,500.00	23,473,650.00	(8,592,850.00)	73.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,859,100.00	82,437,662.18	(19,421,437.82)	80.9
Тэтгэврийн даатгал	66,600,300.00	56,785,514.66	(9,814,785.34)	85.3
Тэтгэмжийн даатгал	7,835,100.00	6,457,793.52	(1,377,306.48)	82.4
ҮОМШӨ-ний даатгал	7,835,300.00	4,061,788.62	(3,773,511.38)	51.8
Ажилгүйдлийн даатгал	3,917,700.00	3,026,513.10	(891,186.90)	77.3
Эрүүл мэндийн даатгал	15,670,700.00	12,106,052.28	(3,564,647.72)	77.3
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	49,555,099.61	49,555,099.61	-
Гэрэл, цахилгаан	-	4,254,899.61	4,254,899.61	-
Түлш, халаалт	-	44,893,200.00	44,893,200.00	-
Цэвэр, бохир ус	-	407,000.00	407,000.00	-
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	69,239,600.00	53,892,980.00	(15,346,620.00)	77.8
Бичиг хэрэг	7,739,300.00	5,185,500.00	(2,553,800.00)	67.0
Тээвэр, шатахуун	39,398,500.00	34,326,480.00	(5,072,020.00)	87.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,562,500.00	2,361,000.00	(2,201,500.00)	51.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,789,300.00	5,580,000.00	(209,300.00)	96.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,750,000.00	6,440,000.00	(5,310,000.00)	54.8
<b>Нормативт зардал</b>	101,931,900.00	96,486,543.60	(5,445,356.40)	94.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,308,900.00	79,369,603.60	(3,939,296.40)	95.3
Хоол, хүнс	17,010,500.00	15,691,940.00	(1,318,560.00)	92.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,612,500.00	1,425,000.00	(187,500.00)	88.4
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	41,000,000.00	32,692,660.00	(8,307,340.00)	79.7
Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	16,338,500.00	(1,661,500.00)	90.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000,000.00	1,558,000.00	(6,442,000.00)	19.5
Урсгал засвар	15,000,000.00	14,796,160.00	(203,840.00)	98.6
<b>Томилот, зочны зардал</b>	4,000,000.00	1,780,000.00	(2,220,000.00)	44.5
Дотоод албан томилот	4,000,000.00	1,780,000.00	(2,220,000.00)	44.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,076,000.00	1,508,000.00	(1,568,000.00)	49.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,176,000.00	1,008,000.00	(1,168,000.00)	46.3

**Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400,000.00	-	(400,000.00)	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,707,100.00	9,226,590.00	(3,480,510.00)	72.6
Бараа үйлчилгээний бусад зардал	12,707,100.00	9,226,590.00	(3,480,510.00)	72.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	958,974,194.53	958,974,194.53	-
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	64,513,800.00	64,513,800.00	-
Орон нутгийн төсвөөс	-	64,513,800.00	64,513,800.00	-
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	891,960,394.53	891,960,394.53	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	891,960,394.53	891,960,394.53	-
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	2,500,000.00	2,500,000.00	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,500,000.00	2,500,000.00	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	66,842,166.82	66,842,166.82	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	3,967,975.87	3,967,975.87	-

**3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**3.1** Аудитаар нийт 2,491,648.3 мянган төгрөгийн 11 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 2,491,648.3 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний журналаар орон нутгийн санхүүжилтийн орлого санхүүгийн тайланд тайлагнасан дүнгээс 64,3478.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	64,378.9			1	64,378.9	1	64,378.9				
Мөнгөн гүйлгээний журналаар эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 861,031.5 мянган төгрөг буюу санхүүгийн тайланд тайлагнасан дүнгээс 139,111.2 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	139,111.2			1	139,111.2	1	139,111.2				
Нийт 61,374.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулгын тайланг бэлтгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан.	1	61,374.9			1	61,374.9	1	61,374.9				
Нийт Төсвийн гүйцэтгэлийн тайланг улсын төсөв, орон нутгийн төсөв болон нэгтгэсэн дүнгээр, эдийн засгийн ангиллаар тайлагнаагүй.	1	958,974.2			1	958,974.2	1	958,974.2				
Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон нэг иргэнээр тооцсон төлбөрийн 1,000,412.7 мянган төгрөгийн орлогын сар бүрийн нэхэмжлэх, тооцоо нийлсэн акт зэргийг аудит ирүүлээгүй, санхүүгийн баримтад хавсаргаагүй байна	1	1,000,412.7			1	1,000,412.7	1	1,000,412.7				
Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын	1	10,590.0			1	10,590.0	1	10,590.0				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

2025 оны 01 сарын 27-ны өдрийн 07/87 тоот албан бичгээр ирсэн "Төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит байгууллагуудын эзэмшиж буй газрын судалгаа"-аар Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 11,990.0 мянган төгрөгийн 6 газар, Санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгөд 1,400.0 мянган төгрөг буюу 10,590.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.												
Тайлант онд 116,800.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо цалингийн өглөг данстай харьцуулсан байна.	1	116,800.0			1	116,800.0	1	116,800.0				
Тайлант оны ажил олгогчоос төлөх эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,179.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	5,179.5			1	5,179.6	1	5,179.6				
Тайлант оны цалин хөлсний дэлгэрэнгүй тооцооны хүснэгтийг нягтлан бодох бүртгэлийн цалингийн өглөг дансанд бүртгэхдээ 134,173.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	134,173.0			1	134,173.0	1	134,173.0				
Өмнөх санхүүгийн тайланд урьдчилж олгосон ээлжийн амралтын цалин болох 653.9 мянган төгрөгийн авлагыг эхний үлдэгдлээр тусгаагүй байна.	1	653.8			1	653.9	1	653.9				
Элэгдлээрээ анхны өртгөө өртгөө нөхсөн 43 нэр төрлийн нийт 47,818.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй байна.	1	-			1	-		-	1	-	1	-
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>2,491,648.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>11</b>	<b>2,491,648.3</b>	<b>10</b>	<b>2,491,648.3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>

3.2 Аудитаар нийт 21,413.2 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 21,413.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өглөө.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт 21,413.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ урсгал засварын зардлаас 2,749.2 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 185.0 мянган төгрөг, багаж хэрэгслийн зардлаас 17,090.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 1,389.0 төгрөгийг олгосон байна.	1	21,413.2			1	21,413.2						
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 17 иргэн байгууллагын 127,781.1 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	-					1	-				
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 21 байгууллагын 23,503.8 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	-					1	-				
Эрүүл мэнд даатгалын ерөнхий газартай сар бүр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан боловч ЭМДЕГ-аас 7-12 саруудын санхүүжилтийг олгоогүйн улмаас төлбөртэй үйлчилгээний авлага 127,224.7 мянган төгрөгт хүрч оны эхнээс 98,452.3 мянган төгрөгөөр буюу 6.8 дахин өссөн байна.	1	-					1	-				
Шалгагдагч байгууллагын нэхэмжилсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний баримтыг ЭМДЕГ-аас шалган баталгаажуулж, нийт 22,328.9 мянган төгрөгийн зөрчилтэй үйлчилгээний төлбөрийг хасаж санхүүжүүлсэн байна.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>21,413.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>21,413.2</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 164, хугацаа хоцорч мэдээлсэн 3, хүлээгдэж байгаа 4 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад тохирч байна.	1				1	-
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	<b>-</b>